

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2024/6

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Макро үзүүлэлт	Хэмжих нэгж	2024.VI	2023.VI	2024.V	Өмнөх сараас	Өмнөх улирлаас	Оны эхнээс	Өнгөрсөн жилийн мөн үеэс
ДНБ 2024 оны 1-р улирал	их наяд ₮, оны үнээр	-	13.6	-	-	-	-	7.8% ▲
Инфляц	хувь	5.1	10.6	5.7	0.3% ▲	-	4.3% ▲	-5.5 нэгж хувиар ▼
Ажилгүйдлийн түвшин	хувь	3.9% 2024 оны У4	5.3% 2022 оны У4	3.9% 2024 оны У4	-	-1.3% ▼ нэгж хувиар	-	-1.4% ▼ нэгж хувиар
Төсвийн тэнцэл	тэрбум ₮, өссөн дүнгээр	1287	2025	2028	-741 ▼	-	-	-738 ▼
Ам.долларын ханш	төгрөг	3381.11	3438.26	3381.19	-0.08 ▼	-	-	-57.15 ▼
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар, өссөн дүнгээр	2507	3290	1961	-	-	-	-783 ▼
Нүүрсний экспорт	сая тонн, өссөн дүнгээр	39.4	29.5	31.7	-	-	-	9.9 ▲
Зэсийн экспорт	мян.тонн, өссөн дүнгээр	785.2	764.3	643.1	-	-	-	20.9 ▲
Төв банкны бодлогын хүү	хувь	11%	13%	11%	-1%	-	0%	-2%
Гадаад валютын нөөц	тэрбум ам.доллар	4.74	3.81	5.18	-2.1% ▼	-	-	23.7% ▲
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	хувь	5.84%	8.66%	6.24%	-0.4 нэгж хувиар ▼	-	-	-2.81 нэгж хувиар ▼

ОНЦЛОХ СТАТИСТИК:

Инфляц буурсаар	Инфляц сүүлийн 9 сарын түрш буурсаар байна. 2023 оны 9-р сард 10.1 хувь байсан инфляц сард дунджаар 0.55 функтаар тогмол буурсаар 2024 оны 6-р сард 5.1 хувьтай байна.
-----------------	--

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД:


Шийдвэрүүд	Огноо	Зорилго, үр дүн
Нийслэл Улаанбаатар хот 500 тэрбум төгрөгийн бонд гаргав	2024/6/21	"Нийслэл Улаанбаатар хот анх удаагаа хөрөнгийн зах зээл дээр санхүүгийн бүтээгдэхүүн буюу бонд гаргаж, амжилттай арилжааллаа. Нийт 500 тэрбум төгрөгийн бондыг цан цохиж арилжаа эхлүүлснээс хойш цагийн дотор худалдаж авах захиалга дүүрсэн.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

График


Нөлөөлөл

Инфляц




Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 6 дугаар сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 5.1 хувь, өмнөх оны эцсээс 4.3 хувь, өмнөх сараас 0.3 хувиар өссөн байна. 2024 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүнсний барааны бүлгийн үнэ 4.8 хувиар, хүнсний бус барааны бүлгийн үнэ 5.2 хувиар, барааны бүлгийн үнэ 4.6 хувиар, үйлчилгээний бүлгийн үнэ 6.8 хувиар өсжээ.

Валютын ханш




Америк долларын ханш 2024 оны 6 дугаар сард 3381.11 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 57.15 төгрөгөөр, өмнөх сараас 0.08 төгрөгөөр тус тус суларсан байна. Гадаад валютын нийт албан нөөц өмнөх сараас -2.1%-р буурч, өнгөрсөн жилийн мөн үеэс 23.7%-р өсөж, 4.74 тэрбум ам.долларт хүрэв.

Улсын төсөв



Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2024 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 14.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.9 (35.2%) их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 14.2 их наяд төгрөгт хүрч, 3.6 (34.2%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2024 оны эхний хагас жилд 12.9 их наяд төгрөгт хүрч, тэнцвэржүүлсэн тэнцэл 1.3 их наяд төгрөгийн ашигтай гарчээ.

Гадаад худалдаа



Монгол Улс 2024 оны эхний 6 сард нийт 148 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 13.3 тэрбум ам.долларт хүрсэн байна. Үүнээс экспорт 7.9 тэрбум ам.доллар, импорт 5.4 тэрбум ам.долларт хүрч, тэнцэл 2.5 тэрбум ам.долларын ашигтай гарчээ. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.4 (12.2%) тэрбум ам.доллар, экспорт 332.7 (4.4%) сая ам.доллар, импорт 1.1 (25.9%) тэрбум ам.доллароор тус тус өсөж, тэнцэл 772.4 (23.5%) сая ам.доллароор буурсан байна.

Дэлхийн эдийн засагт

- 2024 онд Монгол Улсын эдийн засаг 5.9 хувь өснө. Эх үүсвэр: Азийн хөгжлийн банк
- Дэлхийн банкнаас Монгол Улсын эдийн засгийг 6.2% өснө гэж таамаглажээ.
- БНХАУ-ын эдийн засаг 2023 онд 5.2% өсөв.

Эх сурвалж:

1. [Статистикийн бюллетень, 6-р сар 2024 он, Үндэсний статистикийн хороо](#)
2. [Статистикийн бюллетень, 6-р сар 2024 он, Монголбанк](#)
3. www.1212.mn, www.mongolbank.mn